

### Монгол хэл 4р анги

#### “Ашдын бэлгээс Амны бэлгэ”

Ээж маань элдэв бэлгэ дэмбэрэлгүй үг хэлэх бүрийд ингэж сануулдаг байлаа. Хот айлын хэдэн хүүхэд бид нэгэн өдөр хойд голоос ус авахаар хувин сав аваад явцгааж байтал Довчин гуайтай санамсаргүй тааралдав. “Хол юманд зорьж байхад ус авахаар яваа хүүхдүүдтэй тааралддаг нь юун аштай вэ дээ. Хэрэг зориг бүтэх нь дээ” гэж ирээд л Довчин гуай өврөөсөө том чихэр гаргаж өгөв. Довчин гуайн хэлсэн үгийг ээждээ хэлтэл:

-Хол юманд явж байгаа хүн аргал түүхээр эсвэл ус авахаар яваа хүнтэй тааралдвал их бэлгэшээж, ажил бүтэх нь сайны тэмдэг гэдэг юм гэв.

- Яагаад? гэж хүү лавлан асуув.

Араг хоосон үүрч яваа хүн заавал аргаа дүүргээд харьж таарна, усанд сав бариад явж байгаа хүн мөн адил. Тэгэхээр ажил бүтэхийн шинж юм шүү дээ гэжээ.

Хүү найз нартайгаа туршихаар шийдэж, араг зэхэж, сумын төв орохоор явж байгаа Жаниахүү ахын замыг тостол биднийг огт тоосонгүй, морио ташуурдан өнгөрч одов. Тэгтэл хүүхдүүд намайг “худалч” хэмээн бид маргалдаж орхилоо. Хүү, ээж дээрээ ирж:

-Жаниахүү ахтай хоосон

араг үүрээд тааралдсан чинь бэлгэшээх байтугай тоосон ч үгүй.

Түүнээс болж хүүхдүүд намайг “худалч” гэлээ гэхэд

ээжнь:

- Өө, тэр Жаниахүү яаж мэдэх вэ? Одоогийн залуус чинь ёс

заншлаа гэж яваа улс даа гээд толгойг минь илснээ “Харин Довчин гуай шиг хуучны хүн мэдэлгүй яах вэ дээ” гэв. Түүнээс хойш ахмад хүмүүсийн бэлгэшээж ярьдаг үгийг их анзаарч сайн тогтоодог болов.

- Замд гарахад чоно тааралдвал үйлс бүтнэ.

- Замд тэмээ туйлбал ачаа хүнд, олз их, сайн явах нь гэж бэлгэшээнэ.

- Агт морь шилгээж, атан тэмээ эвшээхэд эзэн нь заавал бэлгэшээдэг.

- Чанаж буй ходоод хагарах юм бол баяжна гэж бэлгэшээнэ гэх мэтчилэн эдгээр бэлгэшээж ярьдаг үгсийг эргэцүүлж тогтоодог боллоо.

#### 1. Эхийн 1 дүгээр хэсэгт хүүгийн хийсэн үйлдлийн дараалал зөв байгааг олоорой. /1оноо/

А. Довчин гуайтай таарсан, Довчин гуайтай ярилцсан, ээжтэйгээ ярилцсан, найзуудтайгаа туршсан

В. Довчин гуайтай таарсан, ээжтэйгээ ярилцсан, шинэ зүйл мэдсэн, усанд явсан

С. Усанд явсан, Довчин гуайтай таарсан, шинэ зүйл мэдсэн, ээжтэйгээ ярилцсан

Д. Усанд явсан, Довчин гуайтай таарсан, ээжтэйгээ ярилцсан, шинэ зүйл мэдсэн

#### 2. Довчин гуай бэлгэшээх болсон шалтгаан нь юу вэ? /1оноо/

А. Аргал түүхээр явж байгаа хүнтэй таарах нь

В. Ус авахаар явж буй хүүхдүүдтэй тааралдсан нь

С. Хүү найз нартайгаа туршихаар шийдсэн нь

Д. Хүүхдүүд ус авахаар явж байгаа нь

#### 3. Хүүгийн хэлсэн үгсээс аль нь эхийн гол санааг илэрхийлж байна вэ? /1оноо/

А. Түүнээс хойш ахмад хүмүүсийн бэлгэшээж ярьдаг үгийг их анзаарч сайн тогтоодог болов.

В. Түүнээс болж хүүхдүүд намайг “худалч” гэлээ .

С. Чанаж буй ходоод хагарах юм бол баяжна гэж бэлгэшээнэ.

Д. Ээж маань элдэв бэлгэ дэмбэрэлгүй үг хэлэх бүрийд ингэж сануулдаг байлаа.

4. Дараах үгсээс бүгд зөөлрүүлэх үүргээр орсон балархай эгшигтэй хэсгийг ол. /1 оноо/

- А. Гажилтыг, даршилсан, зарчимтай, оршилтой
- Б. Янгирьг, танхимаас, ангирыг, сониныг
- В. Уншихаар, солихоос, харихаар, хожихыг

5. Тохирох балархай эгшигийг нөхөж бичээд, үүргийг тайлбарлаарай. /3 оноо/

Хичээл тар\_в \_\_\_\_\_  
Оюун ухаанаа сор\_в \_\_\_\_\_  
Цэцэг тар\_в \_\_\_\_\_  
Ундаагаа сор\_в \_\_\_\_\_  
Хэрэггүй цаасыг ур\_в \_\_\_\_\_  
Төрсөн өдөрт ур\_в \_\_\_\_\_

6. Үгсэд урт эгшгээр эхэлсэн залгаврыг залгаж бичээрэй. /2 оноо/

зориг+оор=  
охин+оос=  
сорил+ыг=  
танил+аа=

7. Дараах өгүүлбэрээс дүрэмтэй үгсийг түүж бичээрэй. /2 оноо/  
**/Зоргол хайрхныг нутгийхан нь хүзүүгээ нугалаад хэвтэж байгаа согооны хэлбэртэй гэж ярьдаг./**

- А. Балархай эгшиг нь гээгдсэн үгийг бичнэ үү? .....
- Б. Хоолойн “ г ” –тэй үгийг олж бичнэ үү? .....

8. “ Ахмад хүмүүсийн бэлгэшээж ярьдаг үгийг их анзаарч сайн тогтоодог болов.” гэсэн өгүүлбэрийг **уриалсан, зөвлөсөн** өгүүлбэр болгон өөрчилж бичээрэй. /2оноо/

.....  
.....

9. “**Нүүр халаах**” хэлц үгийн эсрэг ба ойролцоо утгатай хэлц үг тус бүр нэгийг бичээрэй. /2оноо/


Ойролцоо утгатай хэлц үг \_\_\_\_\_  
Эсрэг утгатай хэлц үг \_\_\_\_\_

10. “ Буурлаас үг сонс Болсноос ам хүр “ 30-40 үгтэй эх зохион бичээрэй. /4оноо/


.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Математик-4р анги**

1. Тоон шулуун дээрх А цэгийн байршлыг тодорхойлоорой. /1оноо/



2. Дүрсийн талбайн хэмжээг хялбар аргаар тооцоолоорой. (1 см.кв нэгж) /3оноо/



3. Тэнцэтгэл бишийг үнэн байлгах цифрийг нөхөөрэй. /1оноо/


$35700 \div 50 > \square$

4. Тэгшитгэлийн шийдийг олоод хариуг шалгаарай. /2 оноо/

$2900 - k : 9 = 2700$




5. Параллелепипедийн гадаргуугийн талбайн хэмжээг олоорой. / 2нүд=1см / /3оноо /



6. Цэгүүдийг тэмдэглээд, холбож, үүссэн дүрсийг нэрлээрэй.


/3оноо/

A(2;4) M(2;1) T(6;4) K(6;1)



7. Дараах дүрсийг нэрлэж, тэгш хэмээр хувиргаарай.

/2 оноо/



Дүрсийг нэрлэж бичээрэй.

\_\_\_\_\_

8. Боломжийг тооцоолоорой.

/4оноо/

А. 5000 төгрөгийг 1000,500,100,50-тын дэвсгэрт ашиглан,ижил дэвсгэртээр хэдэн янзаар задалж болох вэ? Боломжийг бодож харуулаарай.


Б. 5 .0. 3. 4 цифрүүдээр 2-т хуваагдах 4 оронтой тоо хэдийг зохиож болох вэ?


Нийт-19 оноо